

**2004, 2005 ОНУУДАД МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ  
ДУНД ЗЭРЭГ ӨСӨХ ТӨЛӨВТЭЙ БАЙНА**

**БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН ОГЦОМ ӨСӨЛТ  
2004, 2005 ОНД ҮРГЭЛЖИЛНЭ**

**ХӨГЖИЖ БУЙ АЗИЙН ОРНУУД ДЭЛХИЙН ЭДИЙН  
ЗАСГИЙГ ГҮЙЦЭЖ ТҮРҮҮЛНЭ ГЭЖ АХБ ҮЗЭЖ БАЙНА**

**ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХЫН ТУЛД  
АЗИЙН ЭДИЙН ЗАСАГТ ШИНЭЧЛЭЛ ХИЙХ ХЭРЭГТЭЙ  
БАЙНА**

**Мэдээний талаар лавлагаа шаардлагатай бол:**

Цукаса Маекава

Утас: (63-2) 632-5875

(63-2) 917 - 6251351

И-мэйл: [tmaekawa@adb.org](mailto:tmaekawa@adb.org)

**АХБ-ны хэвлэлийн мэдээний электрон  
хувийг Интэрнет дэх Мэдээллийн Төвөөс**

<http://www.adb.org/media> хаягаар авна уу.

Internet site: <http://www.adb.org>

## **2004, 2005 ОНУУДАД МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ ДУНД ЗЭРЭГ ӨСӨХ ТӨЛӨВТЭЙ БАЙНА**

**Улаанбаатар хот, Монгол Улс (2004.04.28)** ОХУ-д төлөх өрийн асуудал шийдвэрлэгдэж, хувьчлалд дорвитой ахиц гарсан, гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсэн, тус орны экспортын гол бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр өссөнтэй холбоотойгоор Монголын эдийн засгийн өсөлтийн хувь 2004, 2005 онуудад тус бүр нэмэгдэх төлөвтэй байна гэж гэж Азийн Хөгжлийн Банк (АХБ)-аас өнөөдөр гаргасан тайланд дурджээ.

АХБ-аас жил бүр тус бүс нутгийн эдийн засгийн чиг хандлага ирэх жил ямар байх талаар таамаг дэвшүүлдэг *Азийн Хөгжлийн Урьдчилсан Төлөв Байдал* (АХУТБ) хэмээх товхимол эрхлэн гаргадаг бөгөөд 2003 оныход дурдсанаар Монгол улсын Дотоодын Нийт Бүтээгдэхүүн (ДНБ) 2003 онд 5.5 хувиар өссөн бөгөөд 2004 онд 5.8 хувь, 2005 онд 6.0 хувиар тус тус өсөх төлөвтэй байгаа ажээ.

1991 оноос өмнөх хугацаанд хуримтлагдсан хуучнаар ЗХУ-д төлөх өрийн асуудал шийдэгдсэн нь хоёр улсын хооронд худалдаа, хөрөнгө оруулалтын харилцаа сайжрах найдлага төрүүлж байна. Гэвч өрийг барагдуулсан нөхцөл нь 2004 оны төсөвт нилээд хэмжээний дарамт учруулж болох учраас макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах нь Засгийн газрын эн тэргүүний зорилт хэвээр байх болно.

Өвөл өнтэй болж мал үржүүлгийн арга хэлбэр боловсронгуй болсон, мөн газар тариалангийн талбайн хэмжээ нэмэгдсэн зэрэг нь тус улсын ажиллах хүчний гуравны нэг нь хамрагддаг хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл нэмэгдэхэд нөлөөлөхөөр байна. Ноолуурын үйлдвэрлэл, мах боловсруулалтад чанарын өндөр стандарт тавигдах болсон хийгээд шинээр хэд хэдэн алтны уурхай нээгдсэний дүнд боловсруулах аж үйлдвэр, уул уурхайн салбарт өсөлт гарна.

Нийслэл хот хурдацтай өргөжин тэлж, илүү боловсронгуй үйлчилгээний хэрэгцээ нэмэгдэхийн хирээр ДНБ-ий 50 гаруй хувийг дангаараа бүрдүүлдэг үйлчилгээний салбар, мөн түүнчлэн барилгын салбарт өсөлт гарах хандлагатай байна. SARS өвчний улмаас 2003 онд 21 хувиар буурсан аялал жуулчлалын салбарын сэргэлт үйлчилгээний салбарын өсөлтөд хувь нэмрээ оруулна.

Амьжиргааны түвшин дээшлэхийн хэрээр хэрэглээний бараа бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ өсөх болон уул уурхай, барилгын салбарын үйлдвэрлэл өргөжихийн хэрээр тэдгээрт шаардлагатай импортоор оруулж ирдэг машин, тоног төхөөрөмжийн эрэлт хэрэгцээ өсөхөөр байгаатай холбоотойгоор 2003 онд гадаад худалдааны тэнцлийн алдагдал ДНБ-ий 14 хувьтай тэнцэх төлөвтэй байна. Гэхдээ гадаадад ажиллагсдаас гуйвуулах бэлэн мөнгө, гадаадын зээл, тусламж болон уул уурхайн салбарт хийгдэх гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ өсөх төлөвтэй байгаагаас үзвэл гадаад худалдааны алдагдалыг нөхөх боломжтой.

Эдийн засгийн өсөлтийг ядуурлын бууруулахад ашиглахад ихээхэн хүчин чармайлт гаргах хэрэгтэй хэмээн АХБ Монгол Улсын засгийн газарт зөвлөж байна.



## **БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН ОГЦОМ ӨСӨЛТ 2004, 2005 ОНД ҮРГЭЛЖИЛНЭ**

**Бээжин, БНХАУ (2004.04.28)** Засгийн газраас хэт халсан эдийн засгаа амраах хүчин чармайлт гаргаж буй боловч БНХАУ-ын эдийн засгийн огцом өсөлт 2004, 2005 онд үргэлжилнэ. Эдийн засгийн өсөлт 2003 онд 9,1 хувь байсан бол амьсгалын замын цочмог халдварын хам шинж (SARS) өвчний ноцтой тархалт гарсан 2004 онд өсөлт нь 8,3 хувь, 2005 онд 8,2 хувь орчим байх төлөвтэй байна гэж Азийн Хөгжлийн Банкн үндсэн тайланд дурьджээ.

Эдийн засгийн хүчирхэг дэвшил нь Дэлхийн Худалдааны Байгууллагад гишүүнээр элссэнтэй холбоотойгоор авч явуулсан дорвитой шинэчлэл, сүүлийн зургаан жилийн турш явуулсан санхүүгийн идэвхитэй бодлогын үр дүнг харуулж байгаа юм.

Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн хандлагад дүгнэлт өгдөг АХБ-ны жил тутмын “Азийн хөгжлийн урьдчилсан төлөв байдал 2004” товхимолд БНХАУ-ын хөгжил дэлхий нийтийн эдийн засгийн өсөлтөд 15 хувь хүрнэ гэсэн байна. БНХАУ-ын хүчирхэг дэвшил бүс нутгийн бусад хэсгийн эдийн засгийн өсөлтөд дэмжлэг болох ажээ.

Засгийн газар нь зээл ихээр олгох явдлыг тогтоон барьж, өсөлтийн тэнцвэртэй загварт илүү анхаарах, хөдөө орон нутагт тусламж дэмжлэгээ нэмэгдүүлж, нийгмийн хөгжилд түлхүү анхаарах талаар алхмууд хийж байна. Энэ нь эдийн засгийн хэт халалт, нийгэм-эдийн засгийн тэнцвэргүй хөгжилд анхаарал хандуулах чиг шугамд нийцэж байгаа юм. Хөрөнгө оруулалтыг хэт өсгөх, зарим салбарын хэт хөгжилд хяналт тавих зорилгоор явуулсан мөнгөний бодлогыг дэмжиж, гүйцэд хэрэгжүүлэхийн тулд мөнгө, санхүүгийн талаар нэмэгдэл арга хэмжээ авах шаардлагатай болж байна.

Эрчимтэй хотжилт, хүн амын орлогын өсөлттэй уялдан хэрэглээний өсөлт 2004, 2005 онд есөн хувь орчимд хүрч, хөрөнгө оруулалт бараг 50 хувиар буурч жилд 16 хувь орчим байх аж. Экспортын хувьд 2004, 2005 онд өсөлт үргэлжлэх боловч хурдац нь арай буурч 15 хувь орчимд байх бололтой. Экспортын татварыг бууруулж хөнгөлөлт үзүүлсэн явдал үүнд зарим талаар нөлөөлсөн. Худалдааны талаархи зөрчил, ялангуяа АНУ болон Европын Холбоотой хийх худалдаанд гарсан зөрчил 2004, 2005 онд улам нэмэгдэж, экспортын өсөлтөд саад үүсгэж болно. Эерэг талаас нь харвал дэлхийн эдийн засгийн сэргэлт худалдаанд дэмжлэг болно.

БНХАУ банкны системийн сул байдал, улсын үйлдвэрийн газрын өөрчлөл шинэчлэлт, ажлын байр бий болгох, ядуурлыг бууруулах, нийгмийн хамгааллын системд өөрчлөл шинэчлэлт хийх зэрэг бэрхшээлтэй асуудлуудтай мөн тулгарсаар байна.

Хятадын хөдөө нутгийн нэн ядуу 28 сая хүн амын ихэнх цаашид ч хүн амьдрахын аргагүй ноцтойгоор эвдрэлд орсон газар нутагт амьдрах буюу өтөл нас, ажлын чадвараас болж зах зээлийн эдийн засгийн гадна орхигдох болж байна. Нэн ядуучуудыг хамгаалахын тулд суурин газруудад нэвтрүүлсэнтэй ижил амьжиргааны наад захын стандартыг хамгаалах тогтолцоог бий болгох хэрэгтэй байна. Одооны мөрдөж буй хөдөөд ядуурлыг бууруулах хөтөлбөрийг өдрийн орлого нь 625 юанаас дээгүүр боловч олон улсын жишиг болох 1 ам. доллараас доогуур орлоготой хүмүүст түлхүү хандуулах замаар өөрчилж болох юм.

“Азийн хөгжлийн урьдчилсан төлөв байдал”-д хот, суурин газрын хүн амын орлогыг тогтоон барьж, хэрэглээний зарлагын өсөлт, хөгжилд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх арга зам эрэлхийлж олох нь зүйтэй гээд энэ нь санхүү, эдийн засгийн шинэ бүтээгдэхүүн, арга хэрэгслийг бий болгон хөгжүүлэхийг шаардана гэсэн дүгнэлт хийжээ.

# ХӨГЖИЖ БУЙ АЗИЙН ОРНУУД ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙГ ГҮЙЦЭЖ ТҮРҮҮЛНЭ ГЭЖ АХБ ҮЗЭЖ БАЙНА

**Сөүл, БНСУ (2004.04.28)** Бүс нутгийн худалдаа өргөжиж өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний эрэлт өндөр байгаа нь хөгжиж буй Азийн орнуудын эдийн засгийн өсөлтийг 6.8 хувьд хүргэж Ази тивийг дэлхийн хамгийн динамик өсөлттэй эдийн засагтай бүс нутаг болгоно гэж өнөөдөр Азийн Хөгжлийн Банк (АХБ)-наас өнөөдөр гаргасан томоохон тайланд дурджээ.

Иракийн мөргөлдөөн, газрын тосны үнийн өсөлт, SARS, жилийн эхний хагаст аж үйлдвэржсэн орнуудын эдийн засаг илааршах явц удаан байсан хэдий ч 2003 онд Азийн эдийн засаг тааварлаж байснаас илүү буюу 6.3%-иар өсчээ гэж Манилад төвтэй АХБ тус банкнаас эрхлэн гаргадаг эдийн засгийн хамгийн чухал хэвлэл болох “Азийн Хөгжлийн Урьдчилсан Төлөв Байдал” (АХУТБ) хэмээх товхимолд дурдсан байна. АХУТБ нь тус бүс нутгийн 41 улс тус бүрийн эдийн засгийн чиг хандлагыг задлан шинжилж, урьдчилсан таамаг дэвшүүлдэг хэвлэл юм.

“Бүс нутгийн худалдааг нэмэгдүүлэхэд нөлөөлж буй байгаа гол түлхэц хүч нь БНХАУ-ын эдийн засгийн хурдацтай өсөлт юм. БНХАУ-ын Зүүн болон Зүүн Өмнөд Азийн улс орнуудаас авах импортын хэмжээ нэмэгдсэн нь тэдгээр улс орнуудын эдийн засагт эерэгээр нөлөөлсөн бөгөөд 2004 онд Хятадын эдийн засгийн өсөлтийн хурдац илүү тогтворжих хандлагатай байгаа хэдий боловч ирэх хоёр жилд бүс нутгийн худалдаа нь хөгжиж буй Азийн орнуудын эдийн засгийн өсөлтийн гол түлхэц хүч хэвээр байх болно” гэж АХБ-ны Ерөнхий эдийн засагч Ифзал Али хэлсэн байна.

Өргөжин тэлж буй бүс нутгийн худалдаанаас гадна Азийн эдийн засгийн өсөлтөд нөлөөлөгч хоёр дахь гол хүч бол өргөн хэрэгцээний барааны эрэлт юм. 2003 онд өргөн хэрэгцээний бараа бүтээгдэхүүнд зарцуулсан мөнгөний хэмжээ Зүүн болон Зүүн Өмнөд Азийн ялангуяа БНХАУ, Индонез, Малайз, Филиппин, Тайландийн эдийн засагт чухал түлхэц болж өгчээ. Өмнөд Азид ялангуяа Энэтхэгт мөн ийм байдал ажиглагдаж байгаа нь тэмдэглүүштэй хэрэг юм.

ДНБ-ий өсөлтөд өргөн хэрэглээний барааны эрэлт улам бүр чухал үүрэг гүйцэтгэх болсон нь ихэнх улс орнуудад төсвийн тэлэх бодлого, мөнгөний уян хатан бодлого явуулсан, түүнтэй холбоотойгоор зээлийн хүү бага байсан явдал нөлөөлсөн гэж ноён Али хэлсэн үгэндээ дурджээ.

Улам бүр хүрээгээ тэлж буй хот суурин газрын дундаж давхаргынхан болон хүн амын харьцангуй залуу хэсэг хөгжиж буй Ази даяар хэрэглээний уламжлалт зан үйлийг үндсээр өөрчилж байна. Тус бүс нутгийн эдийн засгийн хэтийн төлөвт итгэх итгэл өндөр байна гэж ноён Али цохон тэмдэглэв.

АХУТБ-д тэмдэглэсэнээр 2005 онд Азийн улс орнуудын ДНБ нийлбэр дүнгээрээ 6.7%-иар өсч БНХАУ, Энэтхэг, Хятад, Тайланд, Вьетнам бүс нутгийн өсөлтийг тэргүүлнэ.

Энэхүү хурдацтай өсөлт нь Азийн хөгжиж буй улс орнуудад ядуурлын эсрэг тэмцэх, орлогын тэгш бус байдлыг бууруулах, одоогийн өсөлтийг тогтвортой байлгахад туслах бизнесийн хөрөнгө оруулалтыг татахад чиглэсэн бодлогын шинэчлэл хийх онцгой боломж олгоно гэж ноён Али мөн дурдлаа.

Азийн эдийн засгийн хэтийн төлөв ийм нааштай дүр зурагтай байгаа хэдий ч түүнд терроризмын аюул занал, SARS, шувууны ханиад гэх мэт халдварт өвчин тахал, болон аж үйлдвэржсэн орнуудын эдийн засгийн харилцан адилгүй эрүүлжих явц зэрэг боломжит эрсдлүүд нөлөөлж болох юм гэж АХУТБ-д дурджээ.

Бүс нутгийн хэмжээний эрсдлийн тоонд БНХАУ хэт их хэмжээний хөрөнгө оруулалтыг хязгаарлах гэснээс болж тус орны эдийн засаг огцом удааширч болох ба ингэвэл энэ нь бүс нутгийн худалдааны өсөлтийн хурдцад сөргөөр нөлөөлнө. Түүнээс гадна, тус бүс нутаг дахь гадаад валютийн нөөц асар хурдацтай өсч байгаа нь мөнгө зээлийн жолоодлогогүй тэлэлтэд хүргэж болзошгүй бөгөөд энэ нь шинэ санхүүгийн хямрал үүсэх нөхцлийг бүрэлдүүлж магадгүй юм.

Товхимолд дурдсанаар, тус бүс нутгийн худалдаа нэмэгдэж, эрэлт өссөн зэрэг нь бизнесийн хөрөнгө оруулалт сайжирсаны хамтаар 2004-2005 онд Азийн хэтийн төлвийг тодорхойлох юм.

АХУТБ 2004 -ийн *Хөгжиж буй Ази дахь Гадаадын Шууд Хөрөнгө Оруулалт* хэмээх тусгай бүлэгт хөрөнгө оруулалтын энэхүү чухал хэлбэрийн чиг хандлага, үр нөлөөг авч үзэхийн зэрэгцээ гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахад ямар шинэчлэл хэрэгтэй болохыг тодорхойлжээ.

Ирэх хоёр жилд Зүүн Ази, Зүүн Өмнөд Ази, болон Өмнөд Азийн эдийн засаг сайжрах төлөвтэй байгаа бол Төв Ази болон Номхон Далайн бүс нутагт нэгэн хэвийн түвшингээ барих дүр зураг харагдаж байна. Үүнийг дэд бүс нутгаар үзүүлбэл:

**Зүүн Ази:** 2003 онд SARS болон бусад хүчин зүйлүүд нөлөөлсөн хэдий ч ДНБ нийлбэр дүнгээрээ 6.5%-иар өссөн нь таамаглаж байснаас илүү байна. 2004 онд тус бүсийн дундаж өсөлт нь 6.9% буюу ойрын 4 жилд хамгийн өндөр байх ба харин 2005 онд 6.8% байх бололтой. Ийнхүү Зүүн Азийн 2004-2005 оны төлөв байдал нааштай дүр зурагтай байна. Өнгөрсөн онд тус бүс нутгийн улс орнуудын эдийн засгийн нөхцөл байдал харилцан адилгүй байв. Жишээ нь: Дотоодын эрэлтийн өсч, экспортын хэмжээ нэмэгдэж, гадаадын хөрөнгө оруулалт эрч хүчээ авч байгаагийн ачаар БНХАУ 9.1%-ийн өсөлттэйгээр бүс нутагтаа тэргүүлэн байна. 2004, 2005 онуудад ч мөн БНХАУ 8.3%, 8.2%-ийн тус тус өсөлттэйгээр бүс нутагтаа тэргүүлнэ. БНХАУ-ын Хонконг, БНСУ, БНХАУ-ын Тайпайд 2004-2005 онуудад дотоодын эрэлт төдийгүй экспортын хэмжээ ч урьдынхаас нэмэгдэх төлөвтэй байна.

**Зүүн өмнөд Ази:** Ар араасаа цувсан гадаад шок нүүрлэсэн байсан хэдий ч энэ бүс нутгийн эдийн засаг 2003 онд 4.6%-иар өссөн нь төсөөлж байснаас даруй хагас гаруй хувиар илүү байна. Тус бүс нутгийн ДНБ 2004 онд 5.7% болж хурдсах бол харин 2005 онд яльгүй удааширч 5.4% болох юм. 2003 онд хамгийн хурдацтай өсөлттэй байсан Тайланд, Вьетнам 2004-2005 онд мөн л тус бүс нутгийнхаа тэргүүлэгч эдийн засагтай орнуудын нэг байх юм байна. 2003 оны байдлаар Камбож, БНЛАУ-ын эдийн засаг харьцангуй эрч хүчтэй байдлаа хадгалсан бол Индонез, Филиппинд ДНБ-ий өсөлт дунд зэрэг байлаа. Сингапурын эдийн засаг 2004-2005 онуудад илаарших төлөвтэй байна.

**Өмнөд Ази:** Өмнөд Азийн ДНБ-ийн өсөлт 2003 онд 6.9 % болж дээд амжилт тогтоосон нь тооцоолж байсан 5.7%-иас хамаагүй илүү байна. Зүүн Азийн бараг бүх улс орнуудын эдийн засгийн үзүүлэлт сайжирснаар тус бүс нутгийн эдийн засгийн өсөлт 2004 онд 7.0%, 2005 онд 6.9%-тай байна. Гэвч энэ таамаглал нь 2003 онд эхлэл нь тавигдсан Энэтхэг, Пакистаны хоорондын томоохон алхам гэж болохуйц энхийн харилцаа, хамтын ажиллагаа үргэлжилж, Афганистан, Непал, Шри-Ланкийн аюулгүй байдал одоогийнхоос дордохгүй тохиолдолд л үнэн байх юм. 2004-2005 онуудад Энэтхэгийн ДНБ өсөх төлөвтэй байгаа бол Пакистаных түүнээс ч илүү өсөх төлөвтэй байна.

**Төв Ази:** 2003 онд Төв Азийн 6 БНУ-ын ДНБ-ий өсөлт нийлбэр дүнгээрээ 8.4%-тай тэнцүү байсан нь АХУТБ 2003-д 5.3% хэмээн таамаглаж байснаас нилээд дээгүүр байна. Тус бүс нутгийн бүх улс орны ДНБ төсөөлж байснаас илүү өсчээ. Тус бүс

нутгийн ДНБ 2004 онд 8.1%, 2005 онд 8.4%-иар өсөх төлөвтэй байна. Газрын тос, шатдаг хий олборлогч 3 оронд газрын тос, шатдаг хийний салбар өсөлтөд гол үүрэг гүйцэтгэсэн хэвээр байх болно. Хэдийгээр 2005 онд газрын тос, шатдаг хийний үнэ буурах магадлалтай байгаа ч тэдгээрийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлснээр хүнд байдлаас гарах боломжтой.

**Номхон Далай:** Номхон далайн дэд бүсийн эдийн засгийн байдал 2003 онд ерөнхийдөө сайн буюу нийлбэр дүнгээрээ ДНБ 2.7%-иар өсчээ. Харин 2004 онд 2.9%, 2005 онд 2.4%-иар өсөх төлөвтэй байна. Номхон далайн бүс нутгийн бүх улс орнууд төсвийн удирдлага, төрийн захиргааны шинэчлэлийн асуудлууд, хувийн хэвшлийн хөгжлийг дэмжсэн орчин бий болгох, мөн дотоодын чадавхийг бэхжүүлэх хэрэгцээ шаардлагыг шийдвэрлэх талаар бэрхшээлтэй учраад байгаа юм.

АХУТБ-ийг АХБ-ны Эдийн Засаг, Судалгааны Газраас жил бүрийн 4 дүгээр сард эрхлэн гаргадаг бөгөөд тухайн жилийнхээ 9 дүгээр сард шинэчилдэг уламжлалтай. Уг товхимолыг бүрэн эхээр нь <http://adbweb/Documents/Books/ADO/2004/default.asp> интернэт хаягаар авч үзэж болно.

### ДНБ-ий өсөлт (жил/ %-иар )

	2003	2004	2005
<b>Зүүн Ази</b>	6.5	6.9	6.8
БНХАУ	9.1	8.3	8.2
Хонконг, БНХАУ	3.3	6.0	5.0
БНСУ	3.1	4.8	5.2
Монгол	5.5	5.8	6.0
Тайпей, БНХАУ	3.2	5.4	4.7
<b>Зүүн Өмнөд Ази</b>	4.6	5.7	5.4
Камбож	5.0	5.4	5.4
Индонез	4.1	4.5	4.5
БНЛАУ	5.9	6.0	6.2
Малайз	5.2	5.8	5.6
Мянмар	10.6	-	-
Филиппин	4.5	5.0	5.0
Сингапур	1.1	5.6	4.8
Тайланд	6.7	7.2	6.2
Вьетнам	7.1	7.5	7.6
<b>Өмнөд Ази</b>	6.9	7.0	7.2
Афганистан	-	-	-
Бангладеш	5.3	5.7	6.0
Бутан	6.5	7.0	8.0
Энэтхэг	7.3	7.4	7.6
Малдив	8.4	5.5	5.0
Непал	2.6	4.0	5.0
Пакистан	5.1	5.5	5.8
Шриланк	5.5	5.0	5.5

	2003	2004	2005
<b>Төв Ази</b>	8.4	8.1	8.4
Азербейджан	11.2	9.0	12.5
Казахстан	9.2	9.5	9.5
Киргизийн Бүгд Найрамдах Улс	6.7	4.1	4.5
Тажикстан	10.2	8.0	5.0
Туркменстан	10.0	10.0	10.0
Узбекистан	4.4	4.5	4.0
<b>Номхон Далай</b>	2.7	2.9	2.4
Кукын арлууд	3.1	2.7	2.9
Фижийн арлууд	5.0	3.9	3.0
Кирибати	2.5	1.8	1.5
Маршаллын арлууд	3.0	2.0	3.0
Майкронежийн Холбооны Улс	0.1	-1.5	2.2
Науру	-	-	-
Папуа Нью Гвиней	2.0	2.8	1.7
Самоа	5.0	4.0	3.5
Соломоны арлууд	3.8	4.5	4.5
Зүүн Тиморын Бүгд Найрамдах Улс	-3.0	1.0	3.0
Тонга	1.9	2.6	2.8
Тувалу	3.0	3.0	-
Вануату	1.6	2.1	2.6
<b>Азийн хөгжиж буй улс орнуудын дундаж</b>	<b>6.3</b>	<b>6.8</b>	<b>6.7</b>

# ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХЫН ТУЛД АЗИЙН ЭДИЙН ЗАСАГТ ШИНЭЧЛЭЛ ХИЙХ ХЭРЭГТЭЙ БАЙНА

**Сөүл, БНСУ (2003.04.28)** Азийн бүс нутагт цутган орж буй олон тэрбум ам.долларын шууд хөрөнгө оруулалтаас ахиухан хүртэхийг хүсвэл Азийн хөгжиж буй эдийн засгууд арилжаанд ашигтай, улс төрийн хувьд тогтвортой орчныг бүрдүүлэх ёстой гэж өнөөдөр гарсан Азийн Хөгжлийн Банкны үндсэн тайланд дурьдсан байна.

Энэ бүс нутгийн эдийн засгийн хувьд эндээс хүсэн хүлээж буй зүйл нь их юм. Азийн хөгжиж буй хэсэгт гадаадын шууд хөрөнгө оруулалт 1970 онд 694 сая ам. доллар байсан бол 2000 онд 138.6 тэрбум, харин 2002 онд 90.1 тэрбум ам.доллар болж буурч байсан. Энэ нь жилд 15,2 хувийн өсөлттэй байсан хэрэг.

“Азийн хөгжлийн урьдчилсан төлөв байдал”-ын “Хөгжиж буй Азид оруулж буй шууд хөрөнгө оруулалт” гэсэн тусгай бүлэгт Азийн эдийн засгийн хандлагад дүн шинжилгээ хийж, “Гадаадын компаниуд арилжаанд нь ашигтай, улс төрийн хувьд тогтвортой орчинд татагдаж байна. Үндэстэн дамнасан компаниуд гадаадад хөрөнгө оруулах талаар шийдвэр гаргахдаа чухамхүү энэ онцлогийг гол шалгуур болгосон нь судалгаанаас харагдаж байна” гэж дүгнэжээ. Хөнгөлөлт, урамшуулал амлах нь гадаадын хөрөнгө оруулалтыг татахад ихэнх тохиолдолд үр дүн муутай байдаг.

Бүс нутагт гадаадын шууд хөрөнгө оруулалтыг цутган орж ирэх хэмжээнд байлгахын тулд заавал хамтарсан үйлдвэр байгуулах, дотоодын зарим нэг илүүц шаардлага тавих зэргээр хөрөнгө оруулалтыг хязгаарласан дэг журмаа халах хэрэгтэй байна. “Азийн хөгжлийн урьдчилсан төлөв байдал” товхимолд иймэрхүү хягаарлалтууд нь хөдөлмөрийн бүтээмжийг бууруулж, тухайн орны эдийн засагт сөргөөр нөлөөлөх нь олонтаа байдгийг тэмдэглэжээ. Хамгийн сайн бодлого бол гадаадын компанийн бүрэн эзэмшлийн салбаруудыг дотоодын элдэв хязгаарлалтаар хавчилгүйгээр гүйгээр ажиллуулах явдал юм.

“Олон улсын арилжааны орчин улс бүрийн хувьд ижил учир хөрөнгө оруулалтыг хүлээн авч байгаа орны бодлогын горим болон институцийн хүчин чадлыг энд шийдвэрлэгч хүчин зүйл гэж үздэг” гэжээ. Хөрөнгө оруулалтыг хүлээн авах орон нь хөрөнгө оруулалтыг татах, бизнес, хөрөнгө оруулалтад таатай орчин бүрдүүлэхийн тулд салбарын зохион байгуулалт, дэд бүтэц, урамшууллын зөв бүтцийг бий болгож, бизнес, хөрөнгө оруулалтын таатай уур амьсгал бүрдүүлэх нь чухал. Үүний зэрэгцээ гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой бодлогод нь хөрөнгө оруулалтын дүрэм журам, зохицуулалт ил тод тусгагдсан, төрөл бүрийн зөвшөөрөл, лиценз олгож, баталдаг байгууллагууд нь тодорхой заагдсан байвал зохино.

“Гадаадын шууд хөрөнгө оруулалт болон түүний цаашдын боломж, чадавхид нөлөөлдөг нэгэн чухал хүчин зүйл бол хөгжиж буй орны хувьд засаглалын төвлөрлийг сааруулах бодлого байдаг. Ийм бодлого үндэс сууриа олсон нөхцөлд орон нутгийн эрч хүчтэй удирдлагууд бизнесийн таатай нөхцөл, боломжийн төлөө төвийн хүнд хөшүүн байгууллагын амыг харалгүйгээр өөр хоорондоо өрсөлдөж эхэлдэг. Засгийн газар нь улс орны хөгжлийн зорилготой нийцүүлэх замаар ийм өрсөлдөөнийг хөхиулэн дэмжих хэрэгтэй” гэж тайланд тэмдэглэжээ.

Оновчтой өсөлт, хөгжлийг хангахын төлөө хийж буй өөрчлөлт болон гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах хүчин чармайлтыг зөв хослуулах нь Азийн хөгжиж буй эдийн засгуудад улам амжилттай урагшлан хөгжих боломж олгож байна.